



# ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

## Оршил

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд гүйцэтгэлийн менежментийг төрийн албаныхаа үйл ажиллагаанд идэвхитэй нэвтрүүлж байгаа дэлхийн улс орнуудын дотор бие даасан хуулийн дагуу хэрэглэж буй цөөн хэдэн улсын тоонд манай улс багтдаг. Төрийн албаны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан гаргаж батлах, тэдгээр шалгуур нь юуны түрүүнд шударга, шуурхай, санаачлагатай, ил тод ажиллах замаар эдийн засгийн өндөр, тогтвортой өсөлтийг хангах, энэ үндсэн дээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн хөгжлийн түвшинг дээшлүүлэхэд оруулсан бодитой хувь нэмэр, ахиц дэвшлээр хэмжигдэх ёстой. Ийм цогц арга хэмжээ авч хэрэгжүүлбэл төрийн албаны ажил үйлчилгээний чанар дээшилж, нэр хүнд, нөлөө өсдөг.

Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулсныг УИХ-ын 2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан билээ.

Энэхүү баримт бичигт төрийн албаны эрхэм зорилго нь “Иргэдэд ойрхон, уян хатан, идэвхтэй, санаачлагатай, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн”-д оршино гэж заажээ.

Мөн харилцан уялдаа холбоо бүхий стратегийн 8 зорилгын хүрээнд төрийн албаны шинэтгэлийн цаашдын зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Үүний нэгдүгээрт хэрэглэгчдийг дээдлэх, иргэдэд ойр байх тухай зорилт бий.

Говьсүмбэр аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгийн газрын зүгээс 2009 оны төрийн алба, үйлчилгээний гүйцэтгэлийн чанарыг олон нийтээр үнэлүүлэх, орон нутгийн нийгэм-эдийн засгийн ерөнхий байдал, хөгжлийн талаар иргэдийн санал хүсэлтийг сонсох, мөн аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлүүлэх, олон нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор төрийн алба үйлчилгээний гүйцэтгэлийн чанарыг иргэдээр үнэлүүлэх судалгааг МСНСЗЗ-ын Аслис холбоотой хамтран хэрэгжүүлэв.


Уг судалгааг 2010 оны 2 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд тус аймгийн Сүмбэр, Баянтал, Шивээ-Овоо сумдын нийт иргэдийн 5.0% нь буюу 426 респондентын дунд явуулсан.

Судалгаанд оролцсон иргэдийн нийгэм-эдийн засгийн зарим үзүүлэлтийг харуулбал:

Хариулт	Хувь
18-20	5.3
21-25	21.3
26-30	16.3
31-35	10.6
36-40	16.3
41-45	11.6
46-50	8.1
51-55	6.3
56-60	1.9
60-с дээш	2.5

Насны бүтцийн тухайд залуу болон дунд үеийнхэн зонхилж байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 21.3 хувь нь 21-25 насныхан, 26,9 хувь нь 26-35 насны залуучууд, 27,9 хувь нь 36-45 насны дунд үеийхэн байна. 45-аас дээш насны оролцогчид 18.8 хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 44.2 хувь нь эрэгтэй, 55.8 хувь нь эмэгтэй байсан. Дараах графикаас судалгаанд хамрагдсан иргэдийн хүйсийн харьцааг харж болно.



Энэхүү судалгаанд эмэгтэйчүүд түлхүү хамрагдсан нь өнөөгийн нийгмийн бүтцэд гарч буй ажил эрхлэлтийн байдал, хүн амын шилжилт хөдөлгөөн, төрөлт, нас баралт зэрэг гадаад, дотоод олон хүчин зүйлээс хамаарч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зохист харьцаа алдагдаж буй Монголын нийгмийн амьдралын бодит дүр зургийг тусган харуулж байна. Үүний бас нэг илрэл, баталгаа боловсролын төвшингөөс бас харагдана.

Хариулт	хувь
дээд	40.9
тусгай дунд	13.8
бүрэн дунд	31.6
бүрэн бус дунд	12.2
бага	1.6

Судалгаанд оролцсон иргэдийн 40,9 хувь нь дээд боловсролтой, бараг 55 хувь нь ямар нэг мэргэжил эзэмшсэн байна. 1/3 нь бүрэн дунд боловсролтой, үлдсэн хувь нь бүрэн бус болон түүнээс бага боловсролтой байв.

Хариулт	хувь
Төрийн байгууллагад	17.6
Төсвийн байгууллагад	17.9
Хувийн хэвшилд	30.4
Төрийн бус байгууллагад	10.0
Тэтгэвэр, группт	5.3
Оюутан, сурагч	4.7
Малчин	3.4
Ажилгүй	10.7

Ажил эрхлэлтийн хувьд авч үзэхэд 35 орчим хувь нь төрийн болон төсөвт байгууллагад, 29,8 хувь нь хувийн хэвшилд, 9,8 хувь нь төрийн бус байгууллагад ажилладаг бөгөөд 5,2 хувь нь тэтгэвэр, группд, 4,6 хувь нь оюутан, 3,4 хувь нь малчин, 10,4 хувь нь ажилгүй иргэд байлаа.

Судалгаанд оролцсон иргэдийн нийгэм-хүн ам зүйн байдлаас үзэхэд судалгаанд хамрагдсан түүвэр олонлог эх олонлогоо бүрэн төлөөлж чадахуйц хангалттай төвшинд авагдсан гэж үзэж байна.

## Улс орны ерөнхий байдал, аймгийн нийгэм-эдийн засгийн байдалд иргэдээс өгсөн үнэлгээ

Сүүлийн 2 жилийн хугацаанд өрнөж байгаа дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал, түүнийг дагалдан Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтолцоонд гарч буй хүндрэл бэрхшээл, мөнгөний ханшийн уналт, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, байгаль экологийн доройтол, цөлжилт, бэлчээрийн хомсдолын зэрэгцээ нийгэмд нэрмээс болж буй зуд турхан, хүн амын дунд тархаж буй халдварт өвчин зэрэг сөрөг үзэгдэл, үйл явцын идэвхжлийн үед энэхүү судалгааг явуулсныг онцлон дурьдах нь зүйтэй. Нийгэм, эдийн засаг, байгаль цаг агаарын хүндрэл бэрхшээлтэй энэ цаг үед Говьсүмбэр аймгийн иргэд **өөрсдийн болон улс орон, аймаг, сумын амьдрал ахуйд ямар өөрчлөлт гарсан** талаар дараах үнэлгээг өгсөн байна.

	Маш их сайжирсан	Эерэг өөрчлөлт гарч байна	Хэвэндээ	Муудсан	Маш их муудсан	Мэдэхгүй
Улс орны амьдрал	2.2	16.0	44.7	25.2	5.1	6.7
Аймаг, сумын амьдрал	3.0	22.6	47.2	17.0	3.3	6.9
Таны гэр бүлийн амьдрал	5.8	18.0	<b>58.5</b>	12.2	3.5	1.9

Дээрх хүснэгтэн мэдээллээс харахад судалгаанд оролцсон респондентуудын дундажаар 11.2% нь “улс орон, аймаг, сум, хувийн амьдрал ахуйд эерэг өөрчлөлт гарсан”, 50.1% нь “улс орон, аймаг, сум, хувийн амьдрал ахуйд онцын өөрчлөлт гараагүй, амьжиргааны түвшин буураагүй” гэж тус тус хариулсан байна. Энэ төлөв байдал нь дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хүнд цохилт болж байгаагийн дээр зуд турханы асуудал ард иргэдийн амьдрал томоохон гарц хохирол учруулж байгаа цаг үеийн хэцүү уур амьсгал дор ард иргэд, ялангуяа Говьсүмбэр аймгийн судалгаанд хамрагдсан иргэд улс орон, аймаг, сум болон өөрсдийн амьдрал ахуйн түвшиндээ ихэвчлэн нааштай эерэг үнэлгээ өгсөн нь сайшаалтай зүйл юм.

Харин сөрөг утгатай хариултуудыг нэгтгэж үзвэл дундажаар 11.05% болж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан Говьсүмбэр аймгийн иргэдийн төлөөллийн арван хүн тутмын нэг нь улс орон, аймаг, сум, хувь хүмүүсийн амьдрал ахуй урьд өмнөхөөсөө дордсон гэж дүгнэсэн нь хэдийгээр бага үзүүлэлт ч Говьсүмбэр аймгийн удирдлага, холбогдох албан тушаалтнууд, салбар хариуцсан удирдах ажилтнууд цаашдын үйл ажиллагаандаа анхаарч ажиллах нь зүйтэй.

Эндээс аймаг сумын нийгэм-эдийн засгийн сүүлийн 2 жилийн нөхцөлд үнэлгээ өгсөн байдлыг салган авч судалгаанд оролцсон респондентуудын насны байдалтай харьцуулбал дараах дүр зураг харагдана.

	18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-с дээш
сайжирсан	35.8	22.0	15.5	31.0	45.5
хэвэндээ	40.7	48.8	56.0	40.5	45.5
муудсан	16.0	22.0	22.6	21.4	--
мэдэхгүй	7.4	7.3	6.0	7.1	9.1
	100.0	100.0	100.0	100.0	100.0

18-25 насныхан болон 46-55 насны иргэдийн дор хаяж гурван хүн тутмын нэг нь, 56-аас дээш насны ахмадуудын бараг тал хувь нь аймаг сумын сүүлийн 2 жилийн амьдрал сайжирсан гэж дүгнэсэн нь хэдийгээр улс орны санхүү, эдийн засаг хүндрэлтэй, зуд турханд нэрвэгдсэн хүнд нөхцөл байдалд байгаа ч амьдрал ахуйн түвшин дараа дараагийн жилд улам сайжирна гэсэн итгэл, өөдрөг сэтгэлээр дүүрэн байгааг харуулж байна. Харин манай судалгаанд оролцсон 36-45 насны иргэд тухайн асуудалд харьцангуй сэтгэл ханамжгүй байгаа нь тэдний 22.6% нь сөрөг үнэлгээ өгснөөс харагдаж байна.

Улс орон, аймаг, сум, хувь хүмүүсийн амьдрал ахуйдаа үнэлэлт дүгнэлт өгсөн байдлыг сум сумаар нь харьцуулан үзвэл:

	Баянтал	Сүмбэр	Шивээ-Овоо
сайжирсан	30,3	26,3	18,8
хэвэндээ	24,2	49,1	54,2

муудсан	30,3	17,4	27,1
мэдэхгүй	15,2	7,1	--
	100.0	100.0	100.0

Эндээс харахад Баянтал сумын хөдөлмөрчид аймаг, сумын нийгэм-эдийн засгийн ерөнхий байдалд эерэг болон сөргөөр өгсөн үнэлгээ ижилхэн 30,3% байгаа нь нэгдүгээрт, хамгийн бага хүн амтайн зэрэгцээ бүртгэгдсэн хаяг дээрээ тогтмол байдаггүй, хоёрдугаарт, хувиараа хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал, ажил эрхлэлтийн ерөнхий төвшин нь төрийн болон төсвийн байгууллагад ажиллаж буй байдлаар тодорхойлогддог, гуравдугаарт, хөдөлмөрийн чадвартай иргэдийн нэлээд хэсэг нь эрхэлсэн тодорхой ажилгүй байдаг зэрэг шалтгаан нөхцөлөөс үүдэн орон нутгийн нийгэм, эдийн засгийн тогтолцоонд сэтгэл ханамжтай, ханамжгүй байдал ижил түвшинд байгаа дүр зураг ажиглагдаж байв.

Шивээ-Овоо сумаас судалгаанд оролцсон иргэдийн 18,8 хувь нь сүүлийн 2 жилийн аймаг, сумын амьдрал ерөнхийдөө сайжирсан гэж хариулсан нь бусад хоёр сумтайгаа харьцуулахад доогуур үнэлгээ боловч амьдрал хэвэндээ байна гэж хариулсан иргэдийн 54,2 хувийг анхаарч харгалзвал Шивээ-Овоо сумын иргэдийн тухайд аймаг, сумын амьдралд харьцангуй сэтгэл хангалуун байдаг гэж дүгнэж болохоор байна.

Судалгаанд хамрагдсан Сүмбэр сумын иргэдийн 75 хувь нь аймаг, сумын амьдрал хэвэндээ эсвэл сайжирсан гэсэн эерэг хариулт өгчээ. Энэ нь сүүлийн жилүүдэд Говьсүмбэр аймгийн дэд бүтэц хөгжиж, тоногдож сүйрсэн барилга байгууламжийг дахин сэргээж ашиглалтанд оруулж хүн амыг орон сууцжуулах ажил бодит биелэлээ олж, иргэд боломжоороо бизнес эрхэлж (худалдаа үйлчилгээ, хүн тээвэр г.м) амьдрал ахуйгаа өөд татах бололцоо нэмэгдсэнтэй шууд холбоотой юм. Үүний зэрэгцээ судалгааны мэдээлэл цуглуулахад ажиглагдсан нэг зүйл бол нийгмийн халамж, ялангуяа Хүний хөгжил сангаас олгож буй тэтгэмжийн асуудлыг иргэд ихээхэн сонирхож, хөндөн ярьж байлаа. Учир нь нийгмийн халамжийг юуны өмнө ахмад настан, хүүхэд нялхас авах нь зөв ч төр засаг нийгмийн халамжийн бодлогондоо хөдөлмөрийн чадвартай атлаа эрхэлсэн тодорхой ажилгүй ядуу өрхийг хамруулахгүй орхигдуулдагт сэтгэл дундуур явдагаа манай судалгаанд оролцогчид илэрхийлж байсныг холбогдох албан тушаалтнууд анхаарахад илүүдэхгүй биз.

**Монгол Улсын төрийн гол институтууд болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, орон нутгийн удирдлагуудын үйл ажиллагаанд** Говьсүмбэр аймгийн иргэдээс өгсөн үнэлгээг дараах хүснэгтээс харж болно.

	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Мэдэхгүй
УИХ	0.7	10.3	42.8	25.9	9.3	11.0
Ерөнхийлөгч	3.7	13.4	41.9	23.5	5.7	11.7
Засгийн газар	1.4	14.3	47.7	20.2	5.2	11.1
Аймгийн ИТХ	1.8	14.0	42.8	18.6	6.0	16.8
Аймгийн Засаг дарга	1.4	15.3	41.2	21.4	7.8	12.9
Сумын ИТХ	1.0	11.4	43.4	23.4	8.3	12.4
Сумын Засаг дарга	1.0	12.2	44.4	22.4	6.8	13.2
Багийн Засаг дарга	5.3	19.5	40.4	16.6	6.6	11.6

Иргэд Монгол Улсын Ерөнхийлөгч (маш сайн болон сайн гэж үнэлсэн 17 орчим хувь), аймгийн Засаг дарга (маш сайн болон сайн гэж үнэлсэн 17 орчим хувь), багийн Засаг дарга (маш сайн болон сайн гэж үнэлсэн 25 орчим хувь) нарыг үүрэгт ажлаа сайн гүйцэтгэж байна гэж үнэлсэн нь төр захиргааны бусад институтэд өгсөн үнэлгээнээс 1-14 хувиар илүү байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын үйл ажиллагааг үнэлэх байдал сум тус бүрээр харилцан адилгүй байна. Тухайлбал:

	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээ	Аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн үнэлгээ
--	--	---

	Баянтал	Сүмбэр	Шивээ-Овоо	Баянтал	Сүмбэр	Шивээ-Овоо
Маш сайн	--	1,9	2,3	--	1,8	--
Сайн	16,7	13,3	15,9	9,7	16,6	13,0
Дунд	36,7	43,6	43,2	41,9	41,0	41,3
Муу	30,0	17,1	18,2	35,5	18,3	28,3
Маш муу	6,7	7,1	--	6,5	9,2	2,2
Мэдэхгүй	10,0	17,1	20,5	6,5	13,4	15,2
Нийт	100	100	100	100	100	100

Баянтал сумын иргэд орон нутгийн удирдлагуудын үйл ажиллагаанд Сүмбэр болон Шивээ-Овоо сумдын иргэдээс илүү доогуур үнэлэлт өгч байгаа нь харагдаж байна. Энэ дүр зураг мөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сумын Засаг даргын үйл ажиллагааг дүгнэх байдал дээр ч харагдаж байв. Үүний гол онцлог нь Баянтал сум нь суурин хүн ам багатайн дээр хөдөлмөрийн чадвартай, хүн амын идэвхитэй насны залуу үеийнхэн төв суурин газар руу шилжих эсвэл мал аж ахуй эрхлэх, нийгмийн халамж үйлчилгээ хүртдэг өндөр настнууд нийгмийн бүтцийг нь бүрдүүлж өгдөг зэрэг учир шалтгаан, хүчин зүйлтэй холбоотой юм.

### Говьсүмбэр аймгийн нийгэм-эдийн хөгжлийн талаарх иргэдийн төсөөлөл

Аймгийн иргэд Шивээ-Овоогийн уурхайд ихээхэн итгэл тавьж ирээдүйн хөгжлийн гол түлхүүр байна гэж үзжээ. Ялангуяа Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн дулааны цахилгаан станц барих нь Говьсүмбэр аймгийн хөгжилд голлох үүрэг гүйцэтгэх ёстой гэж 202 хүн (давхардсан тоогоор) хариулсан нь 23,8 хувь болж байна. Шивээ-Овоогийн уурхай одоогийн хэрэгжиж буй төслийн хүрээнд жилд 2,0 сая тонн нүүрс олборлоход 100-аас доошгүй жил ашиглах нөөцтэй гэсэн тооцоо бий ажээ.

Иймээс ч бид судалгаанд хамрагдсан респондентуудаас **ирэх жилүүдэд Говьсүмбэр аймгийн хөгжилд аль салбар, чиглэл голлох үүрэг гүйцэтгэх ёстой гэж Та бодож байна вэ?** гэсэн асуултыг тавихад:

Хариулт	давтамж	хувь
Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр хөгжих	82	9.6
Боловсрол, мэдлэгтэй иргэдийг бэлтгэх	137	16.1
Шивээ-Овоогын нүүрсний ордод түшиглэн ДЦСтанц барих	202	23.8
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх	180	21.2
Ашигт малтмал байгалийн баялагаа нээн илрүүлэх, ашиглах	47	5.5
Гадна, дотны хөрөнгө оруулалтыг татах, дэмжих	78	9.2
Хувийн хэвшил, худалдаа үйлчилгээний хөгжил нь	36	4.2
Дэд бүтэц, харилцаа холбоо, зам тээвэр	84	8.4
Бусад	17	2.0

Түүнчлэн **Говьсүмбэр аймагт жижиг дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх** саналыг судалгаанд оролцсон олон иргэдээс асуухад тэд ихээхэн талархан дэмжиж тус тусын хувийн саналаа дараах байдлаар илэрхийлсэн байна. Үүнд:

1. Эрчимжсэн мал аж ахуй (мах, сүү, цагаан идээ боловсруулах) - 18.2
2. Жижиг дунд үйлдвэр - 12.7
3. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэр (арьс, шир) - 12.7
4. Гурилан бүтээгдэхүүн, хүнсний үйлдвэр (талх, боов, хэрчсэн гурил) - 10.9
5. Гар урлал, оёдол, модон эдлэлийн үйлдвэр (бэлэн хувцас, нэхмэл, гутал, мужаан) - 10.3
6. Газар тариалан, хүнсний ногоо - 10.3
7. Худалдаа, бизнес, үйлчилгээний чиглэлээр - 6.7
8. Уурхайд түшиглэсэн үйлдвэр (үйлдвэрийн багаж, хэрэглэл) - 3.0
9. Ахуй үйлчилгээ, хими цэвэрлэгээ, үсчин - 3.0
10. Аялал жуулчлал, зочид буудал, кафе - 2.4
11. Барилгын материал - 2.4

12.	Ажлын байрны багтаамж ихтэй үйлдвэр	- 1.8
13.	Хог хаягдал, дахин боловсруулах үйлдвэр	- 1.2
14.	Эсгий, эсгий гутлын үйлдвэр	- 1.2
15.	Бусад (тахяны аж ахуй...)	- 3.0

Эндээс харахад судалгаанд хамрагдсан иргэдийн 44.1% нь ямар нэгэн чиглэлээр уул уурхайд түшиглэсэн болон ахуй үйлчилгээний чиглэлээр жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх сонирхолтой байхад 33.9% нь мал аж ахуйн чиглэлээр жижиг дунд үйлдвэрлэл явуулах бодолтой явдгаа илэрхийлсэн байна. Ер нь судалгаанд хамрагдсан иргэд аймаг, сумын захиргаанаас бодлогоор дэмжвэл хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулж, амьдрал ахуйгаа өөд татах бүрэн боломжтой гэсэн саналыг дэвшүүлж байв.

### Төрийн алба, үйлчилгээний гүйцэтгэлийн чанарыг иргэдээс үнэлсэн байдал

**Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжээ сайжруулахад юунд илүү анхаарах хэрэгтэй вэ?** гэсэн асуултанд судалгаанд оролцсон иргэд нэгдүгээрт, хүнд сурталгүй, хөнгөн шуурхай үйлчлэх, хоёрдугаарт, ил тод, нээлттэй байдлыг эрхэмлэн ажиллах, гурвдугаарт, танил тал, гар харсан байдал гаргуулахгүй байх хэрэгтэй гэж хариулсан байна. Энэхүү асуултанд хариулсан байдлыг хүснэгтээр харуулвал:

Хариулт	давтамж	хувь
Ил тод, нээлттэй байдлыг эрхэмлэн ажиллах	154	18.0
Хүнд сурталгүй, хөнгөн шуурхай үйлчилэх	190	22.2
Танил тал, гар харсан байдал гаргуулахгүй байх	150	17.5
Хууль тогтоомжийн биелэлтэд анхаарах	72	8.4
Нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх	85	9.9
Иргэдийн санаа бодлыг шийдвэртээ тусгах	100	11.7
Нийгмийн эмзэг, ядуу хэсэгт анхаарах	105	12.3

Олон улсын шинжээчдийн болон дотоодын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудаас явуулсан судалгаагаар Монгол Улсад авилга, хүнд суртал нийгэмд газар авсан гэсэн ерөнхий үнэлгээ гарсан байдаг. Иймээс ч бид Говьсүмбэр аймгийн судалгаанд хамрагдсан иргэдээс **Төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлснийхээ төлөө тэднээс шан харамж нэхэх байдал гардаг эсэхийг** лавлавал судалгаанд оролцсон иргэдийн 87,2 хувь нь үгүй гэж хариулсан бол 12,8 хувь нь тийм гэжээ.

1. Үгүй	- 87.2
2. Тийм бол	- 12.8
- Шүүх, цагдаа	- 31.6
- Сургууль	- 21.1
- Эмнэлэг	- 21.1
- Газрын алба	- 15.8
- Иргэний бүртгэл	- 10.5

Тийм бол төрийн албаны ямар байгууллагад ийм явдал гарч байгааг иргэдээс тодруулбал 31,6 хувь нь цагдаа, 21,1 хувь нь сургууль, 21,1 хувь нь эмнэлэг, 15,8 хувь нь газрын алба, 10,5 хувь нь иргэний бүртгэлийн албанд дээрх байдал байдаг гэж хариулав.

Говьсүмбэр аймгийн иргэдээс төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн чанарыг үнэлүүлэхэд дараах байдлаар үнэлсэн байна.

	Бүрэн хангалттай	Хангалттай	Төдийлөн хангалтгүй	Хангалтгүй	Мэдэхгүй
Хууль тогтоомжийн талаарх мэдээлэл сурталчилгаа, хэрэгжилт нь хэр байна вэ?	14.2	41.8	33.3	8.4	2.0

Гэмт хэргийг бууруулах, түүнтэй тэмцэх талаар хийгдэж байгаа ажлыг хэрхэн дүгнэж байна вэ?	12.3	24.2	32.7	22.9	8.0
Архидан согтуурахтай тэмцэх талаарх арга хэмжээ хэр байна.	9.4	35.6	34.6	18.1	2.3
Засгийн газраас гаргаж байгаа бодлого шийдвэр танд хүрч байна уу ?	19.0	34.0	30.0	13.3	3.7
Ядуурал, ажилгүйдэлтэй тэмцэх талаар явуулж байгаа арга хэмжээ	10.2	49.3	35.2	4.9	0.3
Боловсролын материаллаг бааз хэр байна. Сургалтын чанар ямар түвшинд байна вэ?	6.7	23.9	32.3	22.6	14.5
Багш нарын хангалт, ур чадварын түвшин ямар байна вэ?	15.7	23.9	23.9	32.1	4.4
Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл танай суманд өсөх хандлага байна уу	31.6	25.9	22.9	14.6	5.0
Байгаль орчныг хамгаалах талаар хангалттай арга хэмжээ авч чаддаг уу?	21.7	41.3	27.3	8.3	1.3
Аймгийн Засаг даргын 2004-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлууд хэр зэрэг бодитой хэрэгжсэн бэ?	31.8	26.9	27.5	12.8	1.0
Аймаг орон нутаг хэр хөгжиж байна бэ?	21.9	30.0	36.9	8.8	2.3
Аймаг сумын удирдлагууд үйл ажиллагаандаа иргэдийн санал бодлыг тусгах, эрх ашгийг нь хамгаалах талаар хийж буй ажлыг та хэрхэн үнэлж байна бэ	20.9	29.9	32.8	12.2	1.4
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, хангамж ямар түвшинд байна бэ	15.9	33.0	33.3	8.9	6.9
Нийгмийн халамж зохих иргэдэд хүрч байна уу.	10.3	40.3	26.7	9.0	13.7
Төрийн байгууллагууд иргэдэд нээлттэй үйлчилж чадаж байна уу. Та хэрэгцээтэй үйлчилгээгээ хүртэж чадаж байна уу.	13.0	25.6	41.3	10.7	9.5
Төрийн албан хаагчид иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчилж чадаж байна уу	15.3	33.7	37.7	11.3	2.0
Төрийн байгууллагууд иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх тал дээр хэр ажиллаж байна вэ	24.9	27.9	33.1	13.1	1.0
Эрүүл аюулгүй хүнсээр хангагдаж чадаж байна уу. Хяналт шалгалт хэр байна	22.5	31.9	31.0	11.1	3.5
Цахилгаан дулаан, усан хангамжийн талаар таны дүгнэлт	15.9	35.5	26.4	15.7	6.5

Дээрх хүснэгтэн мэдээллээс харахад Говьсүмбэр аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээний гүйцэтгэлд Сүмбэр, Шивээ-Говь, Баянтал сумдаас судалгаанд оролцсон иргэдийн өгсөн нийт үнэлгээг дундажаар нь авч үзвэл 24.9% нь хангалттай, 22.6% нь хангалтгүй гэсэн үнэлэлт дүгнэлтийг тус тус өгсөн байна. Эндээс харахад иргэдээс өгсөн эерэг үнэлгээ нь сөрөг үнэлгээнээс 2.3 пунктээр илүү байгаа нь Говьсүмбэр аймгийн ард иргэд аймгийн төрийн байгууллагын өнөөдрийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун явдгийг харуулж байна.



**ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ДҮН**  
(2010.02.19-02.23)

Говьсүмбэр аймаг

**1. Сүүлийн 2 жилийн хугацаанд таны гэр бүл болон орон нутаг, улс орны амьдрал хэрхэн өөрчлөгдөж байна вэ ? (мөр бүрт хариулна уу)**

	Маш их сайжирсан	Эерэг өөрчлөлт гарч байна	Хэвэндээ	Муудсан	Маш их муудсан	Мэдэхгүй
Улс орны амьдрал	2.2	16.0	44.7	25.2	5.1	6.7
Аймаг, сумын амьдралд	3.0	22.6	47.2	17.0	3.3	6.9
Таны гэр бүлийн амьдрал	5.8	18.0	58.5	12.2	3.5	1.9

**2. Ирэх жилүүдэд Говьсүмбэр аймгийн хөгжилд аль салбар, чиглэл голлох үүрэг гүйцэтгэх ёстой гэж Та бодож байна вэ? (гурав хүртэл хариулт сонгож болно)**

1. Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр хөгжих - 9.6
2. Боловсрол, мэдлэгтэй иргэдийг бэлтгэх - 16.1
3. Шивээ-Овоогын нүүрсний ордод түшиглэн ДЦСтанц барих - 23.8
4. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх - 21.2
5. Ашигт малтмал байгалийн баялагаа нээн илрүүлэх, ашиглах - 5.5
6. Гадна, дотны хөрөнгө оруулалтыг татах, дэмжих - 9.2
7. Хувийн хэвшил, худалдаа үйлчилгээний хөгжил нь - 4.2
8. Дэд бүтэц, харилцаа холбоо, зам тээвэр - 8.4
9. Өөр ямар (төмөр зам...) - 2.0

**3. Говьсүмбэр аймаг, танай суманд жижиг дунд ямар үйлдвэрлэл хөгжүүлвэл иргэдийн хэрэгцээ шаардлагад илүү нийцнэ гэж Та үзэж байна вэ ?**

1. Эрчимжсэн мал аж ахуй (мах, сүү, цагаан идээ боловсруулах) - 18.2
2. Жижиг дунд үйлдвэр - 12.7
3. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэр (арьс, шир) - 12.7
4. Гурилан бүтээгдэхүүн, хүнсний үйлдвэр (талх, боов, хэрчсэн гурил) - 10.9
5. Гар урлал, оёдол, модон эдлэлийн үйлдвэр (бэлэн хувцас, нэхмэл, гутал, мужаан) - 10.3
6. Газар тариалан, хүнсний ногоо - 10.3
7. Худалдаа, бизнес, үйлчилгээний чиглэлээр - 6.7
8. Уурхайд түшиглэсэн үйлдвэр (үйлдвэрийн багаж, хэрэглэл) - 3.0
9. Ахуй үйлчилгээ, хими цэвэрлэгээ, үсчин - 3.0
10. Аялал жуулчлал, зочид буудал, кафе - 2.4
11. Барилгын материал - 2.4
12. Ажлын байрны багтаамж ихтэй үйлдвэр - 1.8
13. Хог хаягдал, дахин боловсруулах үйлдвэр - 1.2
14. Эсгий, эсгий гутлын үйлдвэр - 1.2
15. Бусад (тахяаны аж ахуй...) - 3.0

**4. Та дараах төрийн байгууллагын явуулж буй үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгнө үү? (мөр бүрт хариулна уу)**

	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Мэдэхгүй
УИХ	0.7	10.3	42.8	25.9	9.3	11.0
Ерөнхийлөгч	3.7	13.4	41.9	23.5	5.7	11.7
Засгийн газар	1.4	14.3	47.7	20.2	5.2	11.1
Аймгийн ИТХ	1.8	14.0	42.8	18.6	6.0	16.8
Аймгийн Засаг дарга	1.4	15.3	41.2	21.4	7.8	12.9
Сумын ИТХ	1.0	11.4	43.4	23.4	8.3	12.4
Сумын Засаг дарга	1.0	12.2	44.4	22.4	6.8	13.2
Багийн Засаг дарга	5.3	19.5	40.4	16.6	6.6	11.6

**5. Төрийн байгууллага иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжээ сайжруулахад юунд илүү анхаарах хэрэгтэй гэж Та боддог бэ ? (3 хүртэл хариулт сонгох)**

- |   |        |
|---|--------|
| 1. Ил тод, нээлттэй байдлыг эрхэмлэн ажиллах                            | - 17.8 |
| 2. Хүнд сурталгүй, хөнгөн шуурхай үйлчилэх                              | - 22.0 |
| 3. Танил тал, гар харсан байдал гаргуулахгүй байх                       | - 17.3 |
| 4. Хууль тогтоомжийн биелэлтэд анхаарах                                 | - 8.3  |
| 5. Нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх                               | - 9.8  |
| 6. Иргэдийн санаа бодлыг шийдвэртээ тусгадаг байх                       | - 11.6 |
| 7. Нийгмийн эмзэг, ядуу хэсэгт анхаарах                                 | - 12.1 |
| 8. Өөр ямар (залуучуудыг дэмжих, ТАХ-ын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх) | - 1.0  |

**6. Та ер нь төрийн үйлчилгээ авахын тулд төрийн албан хаагчид шан харамж өгөх явдал гарч байсан уу?**

- |                   |        |
|-------------------|--------|
| 1. Үгүй           | - 87.2 |
| 2. Тийм бол       | - 12.8 |
| - Шүүх, цагдаа    | - 31.6 |
| - Сургууль        | - 21.1 |
| - Эмнэлэг         | - 21.1 |
| - Газрын алба     | - 15.8 |
| - Иргэний бүртгэл | - 10.5 |

**7. Та аймаг, орон нутгийн удирдлагын зүгээс иргэдэд үзүүлж байгаа дараах ажил, үйлчилгээний чанарт үнэлгээ өгнө үү (мөр бүрт хариулна уу)**

	Бүрэн хангалттай	Хангалттай	Төдийлөн хангалтгүй	Хангалтгүй	Мэдэхгүй
Хууль тогтоомжийн талаарх мэдээлэл сурталчилгаа, хэрэгжилт нь хэр байна вэ?	14.2	41.8	33.3	8.4	2.0
Гэмт хэргийг бууруулах, түүнтэй тэмцэх талаар хийгдэж байгаа ажлыг хэрхэн дүгнэж байна вэ?	12.3	24.2	32.7	22.9	8.0
Архидан согтуурахтай тэмцэх талаарх арга хэмжээ хэр байна.	9.4	35.6	34.6	18.1	2.3
Засгийн газраас гаргаж байгаа бодлого шийдвэр танд хүрч байна уу ?	19.0	34.0	30.0	13.3	3.7
Ядуурал, ажилгүйдэлтэй тэмцэх талаар явуулж байгаа арга хэмжээ	10.2	49.3	35.2	4.9	0.3
Боловсролын материаллаг бааз хэр байна. Сургалтын чанар ямар түвшинд байна вэ?	6.7	23.9	32.3	22.6	14.5
Багш нарын хангалт, ур чадварын түвшин ямар байна вэ?	15.7	23.9	23.9	32.1	4.4
Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл танай суманд өсөх хандлага байна уу	31.6	25.9	22.9	14.6	5.0
Байгаль орчныг хамгаалах талаар хангалттай арга хэмжээ авч чаддаг уу?	21.7	41.3	27.3	8.3	1.3
Аймгийн Засаг даргын 2004-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлууд хэр зэрэг бодитой хэрэгжсэн бэ?	31.8	26.9	27.5	12.8	1.0
Аймаг орон нутаг хэр хөгжиж байна бэ?	21.9	30.0	36.9	8.8	2.3
Аймаг сумын удирдлагууд үйл ажиллагаандаа иргэдийн санал бодлыг тусгах, эрх ашгийг нь хамгаалах талаар хийж буй ажлыг та хэрхэн үнэлж байна бэ	20.9	29.9	32.8	12.2	1.4
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, хангамж ямар түвшинд байна бэ	15.9	33.0	33.3	8.9	6.9

Нийгмийн халамж зохих иргэдэд хүрч байна уу.	10.3	40.3	26.7	9.0	13.7
Төрийн байгууллагууд иргэдэд нээлттэй үйлчилж чадаж байна уу. Та хэрэгцээтэй үйлчилгээгээ хүртэж чадаж байна уу.	13.0	25.6	41.3	10.7	9.5
Төрийн албан хаагчид иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчилж чадаж байна уу	15.3	33.7	37.7	11.3	2.0
Төрийн байгууллагууд иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх тал дээр хэр ажиллаж байна вэ	24.9	27.9	33.1	13.1	1.0
Эрүүл аюулгүй хүнсээр хангагдаж чадаж байна уу. Хяналт шалгалт хэр байна	22.5	31.9	31.0	11.1	3.5
Цахилгаан дулаан, усан хангамжийн талаар таны дүгнэлт	15.9	35.5	26.4	15.7	6.5

#### 8. Таны нас:

1. 18-20	- 5.3	6. 41-45	- 11.6
2. 21-25	- 21.3	7. 46-50	- 8.1
3. 26-30	- 16.3	8. 51-55	- 6.3
4. 31-35	- 10.6	9. 56-60	- 1.9
5. 36-40	- 16.3	10. 61-ээс дээш	- 2.5

#### 9. Таны хүйс:

1. эрэгтэй	- 44.2	2. Эмэгтэй	- 55.8
------------	--------	------------	--------

#### 12. Таны боловсрол:

1. дээд	- 40.9	4. бүрэн бус дунд	- 12.2
2. тусгай дунд	- 13.8	5. бага	- 1.6
3. бүрэн дунд	- 31.6	6. боловсролгүй	- 0

#### 13. Та хаана ямар ажил эрхэлдэг вэ?

1. Төрийн байгууллагад	- 17.6	5. Тэтгэвэр, группт	- 5.3
2. Төсвийн байгууллагад	- 17.9	6. Оюутан, сурагч	- 4.7
3. Хувийн хэвшилд	- 30.4	7. Малчин	- 3.4
4. Төрийн бус байгууллагад	- 10.0	8. Ажилгүй	- 10.7

#### 14. Таны оршин суудаг, амьдардаг газар:

1. Сүмбэр сум	- 71.5
2. Шивээговь сум	- 17.5
3. Баянтал сум	- 11.0

МСНСЗЗХ-НЫ “АСЛИС” ТӨВ